


БАТЛАВ.СУРГАЛТ, ОЮУТНЫ ХӨГЖИЛ ЭРХЭЛСЭН ПРОРЕКТОР Н.ЭРДЭНЭХҮҮ



ШУТИС-ИЙН "ОЮУТНЫ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ШИЛДЭГ ӨГҮҮЛЭЛ ШАЛГАРУУЛАХ"
УДИРДАМЖ

Зорилго:

Их сургуульд суралцагч оюутнуудын эрдэм шинжилгээ, судалгааны ажлын ур чадварыг дээшлүүлэх, бүтээлч сэтгэлгээ, багийн ажиллагааг хөгжүүлэх зорилгоор эрдэм шинжилгээний шилдэг өгүүлэл шалгаруулж, нийтийн хүртээл болгох.

Хамрах хүрээ:

Их сургуулийн бакалаврын түвшинд суралцагч оюутнууд (суралцагч гадаад оюутнууд) оролцоно.

Хугацаа: 2025 оны 11 дүгээр сарын 03-14-нд зохион байгуулна.

I. Оюутны эрдэм шинжилгээний өгүүлэлд тавигдах шаардлага:

1. Асуудлаа тодорхойлсон байдал, хэрэглээ, ач холбогдол;
2. Тухайн асуудлыг шийдвэрлэсэн байдал, онцлог шийдэл;
3. Техник технологи, эдийн засгийн судалгаа, тооцоолол;
4. Оюутны илтгэх ур чадвар;
5. Эрдэм шинжилгээний өгүүлэл нь бичлэгийн стандарт шаардлагыг хангасан байдал. Өгүүллийн хуудасны тоо 5-аас хэтрэхгүй байх.

Жич: ШУТИС-ийн эрдэм шинжилгээний өгүүлэл бичих стандартыг баримтална.
Холбоос: <https://research.must.edu.mn/page/104>

Эрдэм шинжилгээний шилдэг өгүүллийг шалгаруулах салбар:

Салбар 1. Техник, технологи (Инженерийн болон технологийн чиглэлийн судалгааны ажил хамаарна)

Салбар 2. Байгалийн ухаан, хэрэглээний шинжлэх ухаан (Математик, физик, хими, биологи, экологи, геологи, газар зүйн мэдээллийн систем хамаарна)

Салбар 3. Нийгэм, хүмүүнлэгийн ухаан (Нийгэм, соёл, дизайн, эдийн засаг, менежмент, хэл шинжлэлийн чиглэлийн судалгааны ажил хамаарна)

Шалгаруулалт, үе шат

Оюутны эрдэм шинжилгээний шилдэг өгүүллийн шалгаруулалтыг нэгдсэн байдлаар зохион байгуулна.

Бүрэлдэхүүн сургуулиуд салбар тус бүрд 2-3 шилдэг өгүүллийг шалгаруулж, хэвлэмэл болон файл хэлбэрээр, албан бичгийн хамт 2025 оны 11 дүгээр сарын 04-

ний дотор зохион байгуулах комисст ирүүлнэ. (файл, ррт-г Boldoo143@must.edu.mn, хэвлэмэл материалыг хичээлийн I байр 327 тоотод).

Оюутны эрдэм шинжилгээний шилдэг өгүүлэл шалгаруулах нэгдсэн хурал 2025 оны 11 дүгээр сарын 14- нд Техник, технологийн салбар хуралдаан ШУТИС-ийн номын сангийн 604 тоот, Байгалийн ухаан, хэрэглээний шинжлэх ухааны салбар хуралдаан ШУТИС-ийн номын сангийн 405 тоот "Хурлын танхим"-д, Нийгэм хүмүүнлэгийн салбар хуралдаан ШУТИС-ийн I байрны 203 тоот танхимд тус тус зохион байгуулагдана.

Шагнал урамшуулал:

Эрдэм шинжилгээний шилдэг өгүүллийг салбар тус бүр 3 хүртэл байр эзлүүлэн шагнан урамшуулна. (Шүүгчдийн саналыг үндэслэн салбар хуралдааны оролцоо, үр дүнгээс хамаарч байр, шагналд өөрчлөлт оруулах боломжтой)

I байр Батламж, 800.000 төгрөг

II байр Батламж, 500.000 төгрөг

III байр Батламж, 300.000 төгрөг

Оюутны эрдэм шинжилгээний өгүүллийг удирдан ажилласан удирдагч багш нараас шилдэг удирдагч багшийг тус тус шалгаруулан батламж, мөнгөн шагналаар шагнан урамшуулна.

Оюутнуудын шилдэг эрдэм шинжилгээний өгүүллийг эмхэтгэн хэвлэж хэвлэмэл болон цахим хэлбэрээр нийтийн хүртээл болгоно.

Холбогдох майл хаяг, утас:

Оюутны үйлчилгээний алба
хичээлийн I байр 327 тоот өрөө
321184, 324590-1035
[/Boldoo143@must.edu.mn/](mailto:Boldoo143@must.edu.mn)

ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС